



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

“Соёмбо Ай Би” ХХК-ийн даатгалын зуучлагчийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.2, 38.1.3, 38.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Соёмбо Ай Би” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлэх хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаараа Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулаагүй тохиолдолд олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг “Соёмбо Ай Би” ХХК /Ц.Мөнхбаатар/-д анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН